

ҮЙЛЧЛҮҮЛЭГЧДИЙН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГАА

ОД БҮРТГЭЛ АУДИТ ХХК

2013



ОД БҮРТГЭЛ АУДИТ ХХК
Ослер төв 500 тоот
Самбуугийн гудамж 12А
ЧД, УБ хот
+976-99051826
+976-11319782




ҮЙЛЧЛҮҮЛЭГЧДИЙН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН

СУДАЛГАА – 2013 ОН

ОД БҮРТГЭЛ АУДИТ ХХК нь Чанарын Хяналтын Дотоод Стандартанд заасны дагуу аудитын гэрээт ажил бүрт үйлчлүүлэгчдээс СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГАА авч тухайн аудитын багийн ажлын гүйцэтгэлд үнэлгээ өгдөг билээ. 2013 оны аудитын гэрээт ажилтай холбогдох үйлчлүүлэгчдийн Сэтгэл Ханамжийн Судалгааны үр дүн байгууллагын хэмжээнд нэгтгэгдэн гарлаа.

Сэтгэл ханамжийн судалгаа нь агуулгын хувьд аудитын төлөвлөлт, талбар ажил, аудитын тайлан, үйлчилгээний чанар болон үйлчлүүлэгчдийн санал хүсэлт зэрэг асуудлуудыг хамардаг. Нийт судалгаанд оролцогчдын 20 хувь нь байгууллагын гүйцэтгэх удирдлага байсан бол 80 хувь нь ерөнхий нягтлан бодогчид байжээ.

Найрсаг харилцаатай бөгөөд мэргэжлийн хүрээнд биеэ авч явсан эсэх




Диаграмм-1: Найрсаг харилцаа ба мэргэжлийн биеэ авч явах байдал

Нийт судалгаанд оролцогчдын 90% нь Од Бүртгэл Аудит ХХК-ийн аудитор болон аудиторын туслахууд нь найрсаг бөгөөд мэргэжлийн хүрээнд биеэ авч явж байсан гэж үзжээ.




Аудитын шалгалтыг гүйцэтгэх техникийн ур чадвар хангалттай эзэмшсэн эсэх



Диаграмм-2: Техникийн ур чадвар хангалттай эзэмшсэн байдал

Судалгаанд оролцсон үйлчлүүлэгчдийн 80% нь аудитын багийн гишүүд нь аудитын шалгалтыг чанартай, сайн гүйцэтгэх техникийн ур чадварыг хангалттай эзэмшсэн гэж үзсэн бол 20% нь боломжийн хэмжээнд эзэмшсэн гэж хариулжээ.

Шалгалтаар олж илрүүлсэн зүйлс нь үнэн зөв, шударга, ач холбогдолтой байсан эсэх



Диаграмм-3: Аудитын илрүүлэлтийн үнэн зөв, шударга, ач холбогдолтой байдал

Аудитын шалгалтаар олж илрүүлсэн зүйлс нь үнэн зөв, тухайн үйлчлүүлэгчийн хувьд ач холбогдолтой, шударгаар илэрхийлэгдсэн байсан хэмээн судалгаанд оролцогсдын 85% нь үзсэн бол үлдсэн 15% нь эдгээр үзүүлэлт боломжийн түвшинд байсан гэж хариулжээ.




Үйлчлүүлэгчийн чухал гэж үзэж буй асуудалд зохих анхаарал хандуулж, асуултанд цаг тухайд нь хариулт өгч байсан эсэх



Диаграмм-4: Чухал асуудлуудад анхаарал хандуулах болон зөвлөгөө өгөх байдал

Үйлчлүүлэгчдийн 85% нь Од Бүртгэл Аудит ХХК-ийн аудитын баг нь тэдний чухал гэж үзэж буй болон тулгамдаж буй асуудлуудад зохих анхаарал хандуулж, тэдний тавьсан асуултанд цаг тухайд нь хариулт өгч байсан гэж үзсэн байна.

Аудит нь үйлчлүүлэгчийн хувьд ач холбогдолтой, бодит хувь нэмэр оруулсан эсэх



Диаграмм-5: Ач холбогдол ба бодит хувь нэмэр

Од Бүртгэл Аудит ХХК-ийн аудит, баталгаажуулалтын үйлчилгээ нь үйлчлүүлэгч байгууллагуудын үйл ажиллагаанд ач холбогдолтой бөгөөд бодит хувь нэмэр хангалттай хэмжээнд оруулж байна гэж дүгнэж болохоор байна.



Хэрвээ та энэхүү судалгааны талаар болон манай үйлчилгээний чанар, ёс зүйн асуудлаар санал хүсэлт тавих, мэдээлэл өгөхийг хүсэж байгаа бол дараах холбоосоор холбогдоно уу.

Ж.АРИУНАА

Чанарын Хяналтын Менежер

Утас: +976-93111828, +976-11-319782

Факс: +976-11-319782

И-мэйл: qualitycontrol@odburtgel.mn

Вэбсайт: www.odburtgel.mn

ОД БҮРТГЭЛ АУДИТ ХХК

Улаанбаатар хот

Монгол улс

2014/10/30